



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

Ерөнхий боловсролын сургуулийн багш
нарын сургалт, семинар явуулах тухай

Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хууль, Засгийн газрын 2014 оны 34 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2015 оны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын бие бялдрын хөгжил, хөдөлгөөний эвслийг сайжруулах, биеийн тамирын багш мэргэжилтүүдийг мэдээллээр хангах, ур чадварыг дээшлүүлэх “Идэвхитэй хөдөлгөөн-Эрүүл мэнд” сэдэвт сургалт, семинарыг 2015 оны 01 дүгээр сарын 19-23-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулсугай.

2. Сургалт, семинарыг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, хичээл заах багш нарын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт, семинарт шаардагдах 2.100.000 /хоёр сая нэг зуун мянган/ төгрөгийг нийслэлийн орон нутгийн төсвийн сургалт, семинарын зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Сургалт, семинарыг зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг ахлах мэргэжилтэн А.Болдмаад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

1150500011

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2015 оны сарын 19-ны өдрийн
..... тушаалын нэгдүгээр хавсралт


ЕБС-ийн багш нарын сургалт,
семинар төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Багшийн ажлын хөлс: 5 хоног х 40 цаг х 20.000 төг	800.000 төг
2.	Заалны хөлс:	400.000 төг
3.	Бичиг хэргийн зардал:	200.000 төг
4.	Гарын авлага, сурталчилгаа:	300.000 төг
5.	Видео бичлэг, зураг, монтаж хийлгэх	300.000 төг
6.	Сертификат хэвлүүлэх	100.000 төг
ДҮН:		2.100.000 төг

Боловсруулсан
Хянасан

А.Болдмаа
О.Эрдэнэцэцэг

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2015 оны ...*01. сүүл*... сарын *14*...-ны өдрийн
...*А.Оч*... тушаалын хоёрдугаар хавсралт



ЕБС-ийн багш, арга зүйчдийн сургалт, семинар
хичээл заах багш нарын бүрэлдэхүүн

- | | |
|------------------|--|
| 1. А.Болдмаа | НБТСГазрын ахлах мэргэжилтэн |
| 2. Ж.Тунгалаг | Спортын бэлтгэлийн төвийн Биеийн тамир,
спортын албаны дарга |
| 3. Ц.Март | Монголын Гимнастикийн холбооны зөвлөх багш |
| 4. А.Мөнхтоогоо | Нийслэлийн Засаг даргын дэргэдэх оюутны
шигшээ багийн ахлах дасгалжуулагч |
| 5. Х.Отгонбаатар | Спортын бэлтгэлийн төвийн Биеийн тамир,
спортын албаны мэргэжилтэн |
| 6. О.Баасан | Эрүүл мэнд спортын яамны харъяа спортын
бэлтгэлийн төвийн мэргэжлтэн |
| 7. Л.Туяа | МУБИС-ийн СӨБС-ийн багш, доктор |
| 8. Ж.Чулуунцэцэг | Хан-Уул дүүргийн 34-р сургуулийн биеийн
тамирын багш |
| 9. Г.Бямбасүрэн | "Мандал иог" төвийн иогийн багш |
| 10. Б.Түмэнтөгс | МУИС-ийн багш спортын багш |